

ЗӨВШӨӨРСӨН:  
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ  
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Ц.ЭРДЭМБИЛЭГ

*Ц.Эрдэмбилэг*



БАТЛАВ:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
ЭМГЭГ СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Э.БАЯРМАА

*Э.Баярмаа*



ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН  
“ШҮҮХИЙН АНАГААХ УХААН СУДЛАЛ” -ЫН  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Мэргэшлийн индекс:s(r) 091224  
Сургалтын хугацаа: 2 жил

УЛААНБААТАР ХОТ  
2022 он

## **БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:**

- Э.Баярмаа      Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Эмгэг судлал, Шүүх эмнэлгийн тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, профессор
- Х.Батбаяр      Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Эмгэг судлал, Шүүх эмнэлгийн тэнхим, Анагаах ухааны доктор, Дэд профессор

## **ХАМТРАН АЖИЛЛАСАН:**

### **Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газар**

- А.Амгаланболд      Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын дэд дарга Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэрэгтэй шинжээч эмч
- Б. Ариунзул      Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын сургалт хариуцсан багш, Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэрэгтэй шинжээч эмч

### **Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль**

- Д.Адилзаяа      Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Эмгэг судлал, Шүүх эмнэлгийн тэнхим, Анагаах ухааны доктор, Дэд профессор

## **ХЯНАСАН:**

- П.Эрхэмбаяр      Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр
- Б.Туяа      Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
- Д.Дондогмаа      Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр

## ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН “ШҮҮХ АНАГААХ УХААН СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Хүний амь нас, эрүүл мэндийн маргаантай асуудлыг шийдвэрлэхэд тусгай мэдлэгийн хүрээнд туслалцаа үзүүлдэг шүүх анагаах ухаан нь хуулийн байгууллагын үйл ажиллагаанд гарч буй анагаах ухаан – биологийн холбогдолтой асуудлуудыг шийдвэрлэдэг анагаах ухааны салбар шинжлэх ухаан юм. Шүүх эмнэлгийн шинжилгээ, шинжээчийн дүгнэлт нь: хууль зүйн асуудлыг шийдвэрлэхэд нотлох баримт болон тооцогдож, гэмт хэрэг үйлдсэн этгээд буюу гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектийг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, нас барсан шалтгаан болон хүний биед учирсан гэмтэл, эрүүл мэндийн хохирлын зэргийг тогтоох, гэмтлийн байрлал, шинж чанар, үүссэн хугацаа, эмгэг жамаар нь тодорхойлох, хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийг зөв зүйчлэх үндэс суурь болдог юм.

Шүүх эмнэлгийн практикт хэрэглэгддэг танин мэдэхүйн болон орчин үеийн шинжилгээний арга, техник, шүүх эмнэлгийн шинжилгээгээр илрэх шинж тэмдэг түүнд үндэслэн оношлогоо, дүгнэлтийг анагаахын шинжлэх ухааны ойлголтоор зөв томъёолж сурах, “Шинжээчийн дүгнэлт”-ийг хууль зүй, анагаах биологийн шинжлэх ухааны үндэслэлтэй зөв дүгнэж үнэлэх, онолын мэдлэг, тодорхой чадвар, хандлага олгох асуудлыг шийдвэрлэхэд тусгай үүргийн хүрээнд бэлтгэгдсэн боловсон хүчний хэрэгцээ тулгамдаж байгаа юм.

Шүүх эмнэлгийн шинжилгээний шинжээчийн дүгнэлтийн анагаахын шинжлэх ухааны болон хууль зүйн үндэслэлийн талаархи мэдлэг, чадварыг ерөнхий мэргэжлийн эмчид эзэмшүүлэх нь хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн бүртгэл, мөрдөн шалгах ажиллагааны шатанд болон шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд алдаа дутагдал гаргахгүй, хэргийг бүх талаас нь бодитой, нягт нямбай, үнэн зөв шударга шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын шүүхийн шинжилгээний салбарт ажиллаж буй хүний их эмч нь хүний эрүүл мэндийн байдал болон нас баралт, түүний шалтгааныг тодорхойлох, үндсэн ба дагалдах өвчний онош түүнийг хэрхэн хэрэглэх, шинжилгээний баримт бичгийг хөтлөх, эмгэг өөрчлөлт, шалтгааны тухай мэдлэгтэй, эмнэлзүйн болон эд судлал, бусад лабораторит шинжилгээг явуулах, шинжилгээний талаар анхан шатны мэдлэгтэй байх ёстой билээ.

Энэ асуудлыг шийдвэрлэх, мэргэшсэн боловсон хүчинтэй болохын тулд бидэнд цогц нэгдсэн хөтөлбөрийн дагуу үндсэн мэргэшлийн сургалт явуулах зайлшгүй шаардлага урган гарч байна.

Монгол улсын Эрүүл Эрүүл мэндийн Сайдын 2021 оны А/445 дугаар тушаалаар батлагдсан “Шүүх анагаах ухаан судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийн дагуу тус хөтөлбөрийг шинэчлэн боловсруулав.

Энэхүү хөтөлбөр нь анагаах ухааны чиглэлээр их, дээд сургуулийг бакалаврын зэрэгтэй хүний их эмчийн мэргэжлээр төгссөн, анатомийн эмгэг судлал үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдаж буй резидент эмч нарт зориулагдана.

## ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүний их эмчийн цогц чадамж эзэмшсэн мэргэжилтэнийг элсүүлэн авч, хуулийн байгууллагын үйл ажиллагаанд тулгарч буй анагаах ухаан, биологийн асуудлыг хууль эрх зүйн болон тусгай мэдлэгийн хүрээнд зохих шинжилгээний объектод үзлэг, шинжилгээ хийж бие дааж шийдвэр, дүгнэлт гаргах чадвартай **Шүүх анагаах ухаан судлалын эмч (Doctor of Forensic Medicine)** бэлтгэхэд оршино.

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА

**“Шүүх анагаах ухаан судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:**

Шүүх анагаах ухааны эмчийн мэргэшил эзэмшүүлж буй сургалт нь эмнэл зүй болон эмгэг судлалын онолын үндсэн мэдлэгтэй, шинжилгээг цаг тухайд нь үнэн зөв, өвчний олон улсын ангилалын дагуу оношлох мэдлэгтэй, лабораторийн маркетингийн талаар мэдлэг, чадвартай, хамт олныг удирдан зохион байгуулах, багаар ажиллах, хүнлэг энэрэнгүй сэтгэлтэй, ёс зүйн өндөр боловсролтой, зөв эерэг хандлагатай мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

## ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цогц чадамжтай байна:

1. Хүний их эмч байх (*Medical doctor*)
2. Мэргэжлийн байх (*Professional*)
3. Тасралтгүй суралцагч байх (*Learner*)
4. Харилцагч байх (*Communicator*)
5. Хамтрагч байх (*Collaborator*)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байх (*Community Health Advocate*)
7. Зохион байгуулагч, манлайлагч байх (*Leader*)

Энэхүү цогц чадамж нь шүүх анагаах ухаан судлалын эмч эмчийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, хандлагын тухай ойлголт юм. Үүнд:

### 1. Хүний их эмч байх (*Medical doctor*):

- Шүүх анагаах ухаан судлалын салбарт өөрийн мэргэжлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх;
- Оношийн тухай ойлголт, түүний зөрөөг тодорхойлох, нотолгоонд суурилсан анагаах ухааны мэдлэгтэйгээр оношийг баталгаажуулах, орчин үеийн эмгэг судлалын оношилгооны аргуудыг практикт нэвтрүүлэх чадвартай болох;
- Өвчтөнтэй хүндэтгэлтэй харилцах, хамгийн оновчтой зөв нотолгоонд суурилсан анагаах ухааны дүгнэлт гаргахын төлөө ажиллах;
- Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран

хамгаалагч, төрөл, садны хүнтэй хүндэтгэлтэй ёс зүйтэй харилцах;

- Өвчтөний хувийн нууцыг хадгалах, хүний эрхийг дээдлэх;
- Өвчтөний өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах;
- Эрүүл мэндийн байгууллагын стандарт, тушаал дүрэм, зааварыг мөрдөж ажиллан бүртгэл болон тайлангийн маягтыг зохих журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх;

## **2. Мэргэжлийн байх (Professional):**

- Шүүх анагаах ухаан судлалын эмч нь эрхтэн тогтолцооны анатоми, хистологи, физиологийн хэвийн үйл ажиллагааны талаар мэдлэгт суурилсан өвчин эмгэгийн үе шат, зэрэглэлийг хамарсан эмгэг судлалын өөрчлөлтийг тэдгээрийн шалтгаан, эмгэг жамтай нь уялдуулан гаргах үр дагавар, тавиланг тодорхойлж чадахуйц нотолгоонд суурилсан анагаах ухааны мэдлэгтэй болох;
- Шүүх анагаах ухаан судлалын эмч нь өвчний улмаас нас барсан тохиолдлын үхлийн шалтгааныг эрхтэн тогтолцоо, эд, эсийн түвшинд тодорхойлон оношийг баталгаажуулж, хүн амын дундах өвчин эндэгдлийг статистикийн магадлалтай судлах, үндсэн оношийг эмнэл зүйн болон эмгэг судлалын практикт шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэх.
- Гэмтэл болон өвчний шалтгаантэй эмгэг өөрчлөлтийг хуулийн байгууллагын тулгарсан асуудлын дагуу тодорхойлохдоо Монгол улсад мөрдөгдөж буй үндэсний стандартын дагуу үзлэг шинжилгээг хийж, үндсэн өвчин, түүний хүндрэл дагалдах өвчнүүдийг ялган оношлох, түүний дагуу мөрдөгч, прокурор, шүүх үйл ажиллагаанд оролцон тайлбар өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх мэдлэг чадвартай болох.
- Ерөнхий эмгэг судлалын үндсэн ойлголтуудыг эд, эс, молекул патологийн түвшинд тайлбарлах, эрхтэн тогтолцооны өвчин эмгэгүүдийн үед илрэх бүтцийн өөрчлөлтийг эмнэлзүйн шалтгаан, эмгэг жам, хам шинжтэй холбон ялган оношлох мэдлэгтэй байх;
- Цогцосын шинжилгээний арга аргачлалыг стандартын дагуу зөв эмх цэгцтэй гардан хийж сурах, эрхтэн бүрт илрэх эмгэг өөрчлөлтүүдийг макро болон микро түвшинд ялган оношлох, нэгтгэн дүгнэх;
- Эмнэл зүйн шинжилгээг стандартын дагуу үнэлэх, эд судлалын шинжлэгдхүүнийг макро болон микро түвшинд ялган оношилж, нэгтгэн дүгнэх мэдлэг, чадвартай болох;
- Зайн сургалт болон зайн оношилгооны аргуудыг (e-pathology-net) ашиглах чадвартай болгох;
- Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллан түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй хүндэтгэлтэй харилцах;

## **3. Тасралтгүй суралцагч байх (Learner):**

- Мэргэжлийн нэр төрийг өндөрт өргөж, үнэнч шудрага, чин сэтгэлээсээ хандаж сурах.
- Ажлын байран дээр мэдлэг чадвараа байнга тасралтгүй хөгжүүлж, гадаад хэл дээр мэргэжлийн ном сэтгүүлийг судлах;
- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие дааж тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах,

дүн шинжилгээ хийж сурах;

- Ижил мэргэжлийн эмч нартай багаар ажиллаж, мэдлэг туршлагаа хуваалцах, төрөлжсөн мэргэшил эзэмших чин эрмэлзэлтэй болох.
- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах;

#### **4. Харилцагч байх (Communicator):**

- Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садан, эмнэлгийн мэргэжилтэн нартай зүй зохистой үг хэллэг ашиглан хүнлэг энэрэнгүй, зөв боловсон харилцах, мэргэжлийн харилцаа хандлага, ёс зүйтэй байх;
- Өвчтөнд шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах, шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх;
- Эмч эмнэлгийн мэргэжилтэнтэй харьцахдаа ёсзүйн өндөр боловсролтой байж, мэргэжлийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлдэг байх;
- Өөрийн гаргасан онош дүгнэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлах мэдлэг чадвартай байх;

#### **5. Хамтрагч байх (Collaborator):**

- Шүүх эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар бусад мэргэшлийн эмч нартай мэдлэг, мэдээлэл солилцож, хамтран ажиллах;
- Мөрдөгч, прокурор нартай хамтран ажиллах, хамт олноо удирдан зохион байгуулах чадвартай болох;
- Шүүх анагаах ухаан судлалын эмч хамт олныг удирдан зохион байгуулах, багийн нийгэм олон нийтийн ажилд идэвхтэй оролцож, эерэг хандлагатай болох;

#### **6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (Community Health Advocate):**

- Иргэдийг эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэгтэй болж, түүнийг зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох;
- Хамтран ажиллаж буй хуулийн байгууллагын ажилтан, эмнэлгийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд өөрийн мэргэжлээр зөвлөн туслах мэдлэг, чадвар, хандлагатай болох;

#### **7. Зохион байгуулагч, манлайлагч байх (Leader):**

- Шүүх шинжилгээний тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах мэдлэг, чадвартай болох;
- Нийгэм олон нийтээс зохион байгуулж буй ажилд идэвх санаачлагатай оролцож, хувь хүний чадварыг хөгжүүлж сурах;
- Байгууллагын соёлыг зөв төлөвшүүлэх, хамт олноо зөв үйлсэд уриалан дуудаж ажилладаг манлайлагч байх;
- Монгол хүний эрх үүргийг хуулийн дагуу мөрдөж, хүнлэг, энэрэнгүй, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэхэд идэвх санаачлагатай оролцох;

## ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

### 5.1. Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Монгол Японы эмнэлэг, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх Эмнэлгийн Шинжилгээний Газар нь энэхүү сургалтын үндсэн байгууллага байна. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх Эмнэлгийн Шинжилгээний Газар, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Био-Анагаахын сургуулийн Эмгэг судлал, Шүүх эмнэлгийн тэнхим, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы Эмнэлгийн Эмгэг судлалын тасаг, Эмгэг судлалын үндэсний төв, Цэргийн төв эмнэлгийн Эмгэг судлал-Шүүх эмнэлгийн тасагтай сүлжээ үүсгэн хамтран ажиллана.
- Сургалтын нийт хугацаа 2 жил байна. Тойролтын хугацааг үндсэн болон бусад сүлжээ сургалт эрхлэх эмнэлгүүдийн эмгэг судлалын тасгийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны тодорхой хуваарийг Шүүх Эмнэлгийн Шинжилгээний Газар, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Монгол Японы эмнэлгийн эмгэг судлалын тасаг, Эмгэг Судлалын Үндэсний Төвийн Насанд хүрэгчдийн эмгэг судлалын тасаг, Хүүхдийн эмгэг судлалын тасаг болон Цэргийн төв эмнэлгийн Эмгэг судлал-Шүүх эмнэлгийн тасаг боловсруулна.
- Сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай холбоотой хууль, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтанд заавал хамрагдана.

### 5.2. Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардагатай шинж тэмдэг, суурь мэдлэг, өвчин, гардан үйлдэл

Сургалтын агуулгын хүрээнд шүүх анагаах ухаан судлал үндсэн мэргэшлээр суралцаж байгаа эмч нь сургалтын төгсгөлд бие даан тусламж, үйлчилгээ үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сургагч багшийн хяналт дор шүүх шинжилгээ хийх журмыг дагаж мөрдөх, хүний биед болон цогцост шинжилгээ хийх, шинжилгээний дүгнэлтийг стандартын дагуу бичиж, дүгнэх, эмнэлгийн нөхцөлд нас барсан тохиолдлын үхлийн шалтгааныг зөв тодорхойлох, гаргасан дүгнэлтээ анагаах ухааны үндэслэлтэй тайлбарлах чадвартай, аливаа өвчин эмгэгийн үед илрэх макро болон микро өөрчлөлтүүдийг нэгтгэн дүгнэн ялган оношлох дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж, үндсэн мэргэшлийн сургалтанд оролцоно.

#### 5.2.1. Өвчний шинж тэмдэг (*signs and symptoms*) ерөнхий эмгэг судлалын үндсэн ойлголтууд (аль ч тойролтод тохиолдох):

1. Дасан зохицол (*Adaptation*)
2. Хэт томрол (*Hypertrophy*)
3. Хэт үржил (*Hyperplasia*)

4. Хатингаршил (*Atrophy*)
5. Завсрын үржил (*Metaplasia*)
6. Үхжил ба апоптоз (*Necrosis and types*)
7. Эсийн доторх хуримтлал (*Intracellular accumulation*)
8. Нөсөөний хуримтлал (*Pigment accumulation*)
9. Эсийн гаднах хуримтлал (*Extracellular accumulation*)
10. Шохойжил (*Calcification*)
11. Амилоидоз (*Amyloidosis*)
12. Хиалиноз (*Hyalinosis*)
13. Цочмог үрэвсэл (*Acute inflammation and types*)
14. Архаг үрэвсэл (*Chronic inflammation*)
15. Эдийн эдгэрэл, төлжил, сорвижил (*Tissue repair, Regeneration, Fibrosis*)
16. Хоргүй хавдрын шинж чанарууд (*Characteristic of benign neoplasm*)
17. Хортой хавдрын шинж чанарууд (*Characteristic of malignant neoplasm*)
18. Цус дүүрэлт, цус зогсонгошил (*Hyperemia, Congestion*)
19. Цус алдалт (*Hemorrhage*)
20. Цус бүлэгнэлт, Судас бөглөрөл (*Thrombosis, Embolism*)
21. Шигдээс (*Infarction*)
22. Шок (*Shock*)

#### **5.2.2. Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин эмгэгүүд:**

##### ***Амьсгалын тогтолцооны өвчин эмгэгүүд***

1. Амьсгуурс тэлэх (*Bronchiectasis*) J47
2. Уушгины бөглөрөлт өвчнүүд (*Obstructive pulmonary disease*) J42-J45
3. Уушгины буглаа (*Abscess of lung*) J85
4. Пневмоторакс (*Pneumothorax*) J93
5. Уушги тэлэгдэл (*Emphysema*) J43
6. Амьсгалын эрхтэн тогтолцооны төрөлх гаж хөгжил (*Congenital malformations of nose*) Q30
7. Перинаталь үеийн пневмони P23
8. Перинаталь үед үүссэн уушги-амьсгуурсын дисплази P27
9. Амьсгалын дээд замын сорвижил, зөөлрөл

##### ***Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин эмгэгүүд***

10. Ходоодны үрэвсэл (*Gastritis and duodenitis*) K29
11. Ходоодны шархлаа (*Gastric ulcer*) K25
12. Бүдүүн гэдэсний үрэвсэлт өвчин (*Ulcerative colitis*) K51
13. Элэгний фиброз ба цирроз (*Fibrosis and cirrhosis of liver*) K74
14. Нойр булчирхайн үрэвсэл (*Acute pancreatitis*) K85, K86
15. Мухар олгойн цочмог үрэвсэл (*Acute appendicitis*) K35
16. Цөсний хүүдийн архаг үрэвсэл (*Cholecystitis*) K81
17. Ходоодны хавдар (*Malignant neoplasm of stomach*) C16



18. Бүдүүн гэдэсний хавдар (*Malignant neoplasm of colon*) C18
19. Нарийн гэдэсний хавдар (*Malignant neoplasm of small intestine*) C17
20. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны төрөлх гажиг (*Other congenital malformations of the digestive system*) Q38-Q45
21. Ураг ба нярайн хоол боловсруулах тогтолцооны хямрал (*Digestive system disorders of newborn*) P75-P78
22. Үхжилт энтероколит (*Necrotizing enterocolitis*) K55.3
23. Хришпругийн өвчин (*Hirschsprung's disease*) Q43.1
24. Цэсний сувгийн битүүрэл (*Atresia of bile ducts*) Q44.2
25. Цэсөн цирроз (*Biliary cirrhosis, unspecified*) K74.5

#### **Зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчин эмгэгүүд**

26. Судас хатуурах өвчин (*Atherosclerosis*) I70
27. Даралт ихдэх өвчин (*Hypertensive crisis*) I10-I15
28. Зүрхний ишемит өвчин (*Ischemic heart diseases*) I20-25
29. Кардиомиопати (*Cardiomyopathy*) I42
30. Зүрхний хурц болон архаг дутмагшил
31. Цус эргэлтийн тогтолцооны дамжуулалт, таславчийн төрөлх гажиг (*Congenital malformations of cardiac chambers and connections*) Q20
32. Цус эргэлтийн тогтолцооны бусад төрөлх гажиг (*Congenital malformations of great arteries*) Q25

#### **Мэдрэлийн эрхтэн тогтолцооны өвчин эмгэгүүд**

33. Тархины судасны өвчин ба гавал доторх цус харвалтууд (*Cerebrovascular diseases*) I60-I69
34. Тархины буглаа (*Intracranial and intraspinal abscess and granuloma*) G06
35. Төв мэдрэлийн эрхтэн тогтолцооны гаж хөгжил (*Anencephaly and similar malformations*) Q00
36. Ураг нярайн бүтэлт P21
37. Тархины цус харвалт, шигдээс (*Newborn affected by intrauterine (fetal) blood loss*) P50
38. Тархины цусан хангамж хүчил төрөгчийн дутмагшил (*Other disturbances of cerebral status of newborn*) P91
39. Менингоэнцефалит (*Encephalitis, myelitis and encephalomyelitis*) G04
40. Менингиома (*Benign neoplasm of meninges*) D32
41. Шваннома (*Benign neoplasm of other and unspecified sites*) D36
42. Астроцитома C71
43. Олигодендроглиал хавдрууд C71
44. Үр хөврөлийн хавдар C71

#### **Цус, цус төлжүүлэх эрхтэн тогтолцооны өвчин эмгэгүүд**

45. Фон Виллебрандын өвчин, эмгэг судлалын оношилгоо (*Von Willebrand's disease*) D68.0
46. Судсан дотор түгмэл бүлэнтэл эмгэг судлалын оношилгоо (*Disseminated intravascular coagulation [defibrination syndrome]*) D65
47. Дэлүүний өвчинг ялган оношлох (*Diseases of spleen*) D73
48. Цочмог миелобластын лейкоз (*Myeloid leukemia*) C92
49. Цочмог лимфобластын лейкоз (*Lymphoid leukemia*) C91
50. Аплазийн ба бусад цус багадалт (*Acquired pure red cell aplasia [erythroblastopenia]*) D60
51. Ходжкины лимфома (*Hodgkin lymphoma, unspecified*) C81.9
52. Ходжкины бус лимфома C85.5

#### **Яс, булчин, зөөлөн эдийн өвчин эмгэгүүд**

53. Тулай (*Gout*) M10
54. Остеомиелит (*Osteomyelitis*) M86
55. Яс булчингийн эрхтэн тогтолцооны төрөлх гажиг (*Congenital deformities of hip*) Q65
56. Ахондродисплази (*Achondroplasia*) Q77.4
57. Өрцний ивэрхий (*Congenital hiatus hernia*) Q40.1
58. Өөхөн эдийн хоргүй хавдар (*Benign lipomatous neoplasm*) D17
59. Фибробластын эмгэг (*Fibroblastic disorders*) M72
60. Яс мөгөөрсний үрэвсэлт өвчин M68
61. Яс мөгөөрсний хоргүй хавдар (*Benign neoplasm of bone and articular cartilage*) D16

#### **Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин эмгэгүүд**

62. Арьс ба арьсан доорх эслэгийн халдвар (*Infections of the skin and subcutaneous tissue*) L00-L08
63. Арьсны зонхилон тохиолдох халдварууд (*Dermatophytosis*) B35
64. Арьсны бусад хоргүй хавдар (*Other benign neoplasms of skin*) D23
65. Арьсан доорх эслэгийн бусад эмгэг (*Other disorders of skin and subcutaneous tissue, not elsewhere classified*) L98
66. Арьсны меланом ба бусад өмөн (*Melanoma and other malignant neoplasms of skin*) C43-C44
67. Төрөлх мэнгэ (*Congenital non-neoplastic nevus*) Q82.5
68. Арьсны хоргүй хавдар (*Other benign neoplasms of skin*) D23

#### **Нүд ба түүний дайвар эрхтний тогтолцооны өвчин эмгэгүүд**

69. Конъюнктивит өвчин эмгэг судлалын оношилгоо
70. Эвэрлэгийн өвчин эмгэг судлалын оношилгоо
71. Болорын эмгэг эмгэг судлалын оношилгоо
72. Зовхины эмгэг эмгэг судлалын оношилгоо

### **Чих ба түүний дайвар эрхтний тогтолцооны өвчин эмгэгүүд**

- 73. Гадна чихний халдварт бус өвчин (Noninfective disorders of pinna) H61.1
- 74. Дунд чихний ур (Polyp of middle ear) H74.4

### **Бөөр шээс дамжуулах, бэлгийн эрхтэн тогтолцооны өвчин эмгэгүүд**

- 75. Гломерулонефрит (*Glomerulonephritis*) N08
- 76. Пиелонефрит (*Renal tubulo-interstitial diseases*) N10-N16
- 77. Бөөрний дутагдал (*Acute kidney failure and chronic kidney disease*) N17-N19
- 78. Бөөрний буглаа (Balkan nephropathy) N15.0
- 79. Бөөр шээсний замын гаж хөгжил (*Renal agenesis and other reduction defects of kidney*) Q60
- 80. Бөөрний олдмол уйланхай (*Cyst of kidney, acquired*) N28.1
- 81. Цистит (*Cystitis*) N30
- 82. Бөөр, шээсний замын зонхилон тохиолдох хавдрууд (*Malignant neoplasms of urinary tract*) C64-C68
- 83. Төрөлх хидронефроз (*Congenital hydronephrosis*) Q62.0

### **Нөхөн үржихүй, бэлгийн эрхтэн тогтолцооны өвчин эмгэгүүд**

- 84. Төмсөг дайврын үхжил (*Epididymitis*) N45.1
- 85. Сальпингит ба оофорит (*Salpingitis and oophoritis*) N70
- 86. Бэлэг эрхтний төрөлх гажиг (*Congenital malformations of ovaries, fallopian tubes and broad ligaments*) Q50
- 87. Өндгөвчийн уйланхай (*Follicular cyst of ovary*) N83.0
- 88. Эндометрийн булчирхайлаг зузаарал (*Endometrial hyperplasia*) N85.0
- 89. Умайн лейомиом (*Leiomyoma of uterus*) D25
- 90. Өндгөвчийн хоргүй хавдар, цистаденома (*Benign neoplasm of ovary*) D27
- 91. Үтрээний өмөн (*Malignant neoplasm of vagina*) C52
- 92. Умайн хүзүүний өмөн (*Malignant neoplasm of cervix uteri*) C53
- 93. Умайн их биеийн өмөн (*Malignant neoplasm of corpus uteri*) C54
- 94. Өндгөвчийн өмөн (*Malignant neoplasm of ovary*) C56

### **Жирэмсэн, төрөлт ба төрсний дараах үе**

- 95. Умайн гаднах жирэмсэн (*Ectopic pregnancy*) O00
- 96. Цулцан хураа (*Hydatidiform mole*) O01
- 97. Өсөлтгүй жирэмсэн (*Other abnormal products of conception*) O02
- 98. Зулбалт (*Spontaneous abortion*) O03
- 99. Үр хөндөлт (*Failed attempted termination of pregnancy*) O07
- 100. Эх барихын / төрсний дараах үжил (*Puerperal sepsis*) O85
- 101. Эх барихын цус алдалт (*Hemorrhage in early pregnancy*) O20, (*Postpartum hemorrhage*) O72

102. Эх барихын эмболи O88
103. Манас таталтын урьдал эмгэг (*Eclampsia*) O15
104. HELLP хам шинж (*HELLP syndrome (HELLP), second trimester*) O14.22
105. Төрөлт ба төрөлтийн хүндрэл (*Preterm labor*) O60- (*Other complications of labor and delivery, not elsewhere classified*) O75
106. Ихэс түрүүлэлт (*Placenta previa*) O44
107. Ихэс ховхрол (*Premature separation of placenta*) O45
108. Ихэс шигдэлт (*Placental disorders*) O43
109. Ихсийн үлдэгдэл (*Other obstetric trauma*) O71
110. Хүйн эмгэг (*Morbidly adherent placenta*) O43.2
111. Ихсийн үрэвсэлт эмгэг (*Infection of amniotic sac and membranes*) O41.1
112. Ихсийн цус эргэлтийн хямрал (*Other placental disorders*) O43.8
113. Ихсийн өмөн (*Malignant neoplasm of placenta*) C58

#### **Перинаталь үед үүссэн өвчин эмгэгүүд**

114. Эхийн эрүүл мэнд болон жирэмсэн ба төрөх үеийн хүндрэлээс улбаалсан ураг ба нярайн эмгэг (*Newborn affected by maternal factors and by complications of pregnancy, labor, and delivery*) P00-P04
115. Жирэмсний тээх хугацаа ба ургийн өсөлттэй холбоотой хямрал (*Disorders of newborn related to length of gestation and fetal growth*) P05-P08
116. Перинаталь үеийн амьсгал ба зүрх судасны тогтолцооны өвөрмөц эмгэг (*Neonatal aspiration*) P21-P24
117. Перинаталь үеийн өвөрмөц халдвар (*Congenital viral diseases*) P35-37
118. Хромосомын гаж хөгжил (*Chromosomal abnormalities, not elsewhere classified*) Q90-Q99

#### **Халдварт ба шимэгчит зарим өвчин / Infectious Diseases/**

119. Сүрьеэ (*Tuberculosis*) A15-A19
120. Вируст гепатит (*Viral hepatitis*) B15-B19
121. ДОХ/Хүний дархлал хомсдолын вируст өвчин/ (*Human immunodeficiency virus [HIV] disease*) B20-B24
122. Үжил, үжлийн шок (*Streptococcal sepsis*) A40, (*Other sepsis*) A41
123. Тэмбүү (*Congenital syphilis*) A50, (*Other and unspecified syphilis*) A53

#### **Дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчин**

124. Чихрийн шижин I ба II төрөл (*Type 1,2 diabetes mellitus*) E10-E14
125. Бамбай булчирхайн эмгэг E0-E07
126. Өнчин тархины эмгэгүүд E22-E24
127. Бөөрний дээд булчирхайн эмгэгүүд E25-E27

#### **Шүүх анагаах ухаан**

1. Зулгаралт (*scratch*)

2. Шалбаралт(*abrasion*)
3. Цус хуралт (*bruising*)
4. Шарх (*wound*)
5. Хугарал (*fracture*)
6. Мултрал(*dislocation*)
7. Доргилт (*shake*)
8. Няцралт (*injury*)
9. Таслагдалт(*body dismemberment*)
10. Бэлгийн бойжил (*puberty*)
11. Хурьцал үйлдэх (*interact*)
12. Охин хальсны урагдал (*defloration*)
13. Жирэмслэлт (*pregnancy*)
14. Зулбалт (*miscarriage*)
15. Төрөлт (*birth*)
16. Хөрөлт (*cooling of the body after death*)
17. Хаталт (*cadaveric desiccation*)
18. Хөшилт (*rigor mortis*)
19. Хүүрийн толбо (*post-mortem hypostasis*)
20. Уусалт (*cadaveric autolysis*)
21. Язрал (*putrefaction*)
22. Занданшилт (*mummification*)
23. Намагшилт (*trophy tanning*)
24. Саванжилт (*adiposity*)
25. Механик гэмтлийн нас баралт (*mortality from mechanical injuries*)
26. Хурц иртэй зүйлийн үйлчлэлийн нас баралт (*mortality in the sharps*)
27. Механик амьсгал бүтэлтийн нас баралт (*mechanical asphyxia*)
28. Өндөр болон нам хэмийн үйлчлэлийн нас баралт (*mortality in high and low temperature activities*)
29. Тээврийн ослын гэмтлийн нас баралт (*road traffic trauma*)
30. Галт зэвсгийн гэмтлийн нас баралт (*mortality from gunshot wounds*)
31. Гэнэт нас баралт (*sudden death*)
32. Идэмхий хорын шалтгаант нас баралт (*death due to caustic poison*)
33. Бүтцийн эвдрэл үүсгэгч хорын шалтгаант нас баралт (*deaths due to toxic structural damage*)
34. Цусны гемоглобиныг өөрчлөгч хорын шалтгаант нас баралт (*mortality due to hemoglobin-modifying toxins*)
35. Төв болон захын мэдрэлийн системд үйлчлэгч хорын шалтгаант нас баралт(*death caused by poisons acting on the central and peripheral nervous system*)
36. Архины хордлого(*alcohol poisoning*)
37. Биологийн гаралтай эд мөрийн баримт (*biological evidence*)
38. Хэрэг учирлын газрын үзлэг (*inspection of the place of occurrence*)
39. Нас барсан хугацаа (*date of death*)
40. Цогцосын шүүх эмнэлгийн шинжилгээ (*forensic autopsy*)
41. Цогцост хийгдсэн шинжилгээний дүгнэлт (*autopsy results*)

42. Эрүүгийн ба иргэний хэргийн материал (*criminal and civil case files*)
43. Гэмтэл, түүний үүссэн хугацаа, дараалал (*injury, its occurrence time and sequence*)
44. Гэмтээгч хүчин зүйлийн шинж чанар (*the nature of the offending factor*)
45. Хүний биеийн үлдэгдлээр таньж тогтоох (*Identification by human remains*)
46. Хүнийг эргэж сэргээх (*restoration*)

### **5.2.3. Гардан үйлдлийн жагсаалт :**

#### *Эмгэг судлалын шинжилгээ /Аутопси/-ний гардан үйлдэл*

1. Арьс ба зөөлөн эдийг зүсэж чөлөөлөх Өмнө талын шулуун зүслэг, Лешкегийн зүслэг, Фишерын зүслэг, Хавсарсан зүслэгийн аргуудаар стандартын дагуу эмгэг судлалын шинжилгээг хийх
2. Дотор эрхтний бүрдлийг гаргах Вирховын арга, Киар-Марешийн арга, Лютелийн арга, Абрикосовын арга, Шорын арга, Хосолмол аргуудаар стандартын дагуу эмгэг судлалын шинжилгээг хийх
3. Тархийг шинжлэх Буяльский-Флексикийн арга, Громов-Вирховын арга, Фишерын арга, Титрегийн арга, Остретагийн арга, Шишковын арга, Науменко, греховын аргуудыг ашиглан эмгэг судлалын шинжилгээ хийх
4. Нугасны хөндийг нээх, нугас шинжлэх
5. Эмгэг судлалын шинжилгээнд сорьц авах, зүсмэг бэлтгэх
6. Цогцост илрэх өөрчлөлтүүдийг ажиглан илрүүлэн оношлож эмгэг судлалын протокол бичих, эмнэл зүй эмгэг судлалын дүгнэлт бичих

#### *Амьд сорьцын эд судлалын шинжилгээ /Биопси/-ийн гардан үйлдэл*

7. Улаан хоолой, ходоод, нарийн гэдэс, бүдүүн гэдэс, мухар олгойн өвчний үед эмгэг судлалын дээж авах, дүгнэлт гаргах аргачлал / *MNS 6539-3:2015* /
8. Элэг, цөс, цөсний хүүдий болон нойр булчирхайн эмгэгийн үед эмгэг судлалын дээж авах дүгнэлт гаргах аргачлал / *MNS 6539-4:2015* /
9. Цогцосын шинжилгээний арга, эмгэг судлалын оношийн бүтэц / *MNS 5377-2004* /
10. Төв мэдрэлийн тогтолцооны эмгэгийн үед эмгэг судлалын шинжилгээний дээж авах, дүгнэлт гаргах аргачлал / *MNS 6714-1:2018* /
11. Зүрх, зүрхний хавхлаас, зүрхний зүүн ховдлын туслах төхөөрөмжүүд, судасны эмгэгийн үед эмгэг судлалын дээж авах, дүгнэлт гаргах аргачлал / *MNS 6714-2:2018* /
12. Уушгины эмгэгийн үед эмгэг судлалын дээж авах, дүгнэлт гаргах аргачлал / *MNS 6714-3:2018*

#### *Хистологи лабораторит хийгдэх гардан үйлдэл*

13. Шинжилгээний өмнөх, шинжилгээний болон дараах үед гарч болзошгүй лабораторийн алдааг таньж илрүүлэх
14. Хистохимийн будгийг төлөвлөх, захилах мэдлэг, ур чадвартай байх

15. Иммунохистохимийн будгийг төлөвлөх, захиалах мэдлэг чадвартай байх
16. Дотоод, гадаад хяналт хийх арга, үл тохиролыг тооцох, үнэлгээ өгөх

### ***Хүний биед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээний гардан үйлдэл***

1. Гэмтлийн зэрэг тогтоох үзлэг хийж дүгнэлт гаргах
2. Бэлгийн маргаантай байдал, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн үзлэг хийж, дүгнэлт гаргах
3. Нас тогтоох үзлэг хийж, дүгнэлт гаргах
4. Согтолтын зэрэг тогтоох
5. Ялаас чөлөөлөх шинжилгээ хийх

### ***Цогцост хийгдэх шинжилгээний гардан үйлдэл***

1. Механик гэмтлээр нас барсан тохиолдлын шүүх эмнэлгийн шинжилгээ
2. Ураг нярайд хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ
3. Авто ослын үед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ
4. Амьсгал бүтэлтийн үед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ
5. Гавал тархины гэмтлийн үед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ
6. Галт зэвсгийн үед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ
7. Өндрөөс уналтын үед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ
8. Гэнэт нас баралтын үед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ
9. Осголтын үед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ
10. Цахилгааны гэмтлийн үед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ
11. Хурц иртэй зүйлийн гэмтлийн үед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ
12. Архины хордлогын үед хийгдэх шүүх эмнэлгийн шинжилгээ

### ***Хэргийн материалаар шинжилгээ хийх***

1. Хэргийн материалтай танилцах бие даан дүгнэлт гаргах
2. Хамтарсан шинжилгээ хийж дүгнэлт гаргах

### ***ЭМ-ийн салбарын ажилтаны гэмт хэргийн шинжилгээ***

1. Задлан шинжилгээ хийхэд оролцож дүгнэлт гаргах
2. Хэргийн материалтай танилцан дүгнэлт гаргах

### ***Шүүх хуралдаанд шүүх анагаах ухаан судлалын эмч оролцох***

Шүүх хуралд сууж тэмдэглэл хөтлөх

### ***Шүүх яс судлалын магадлагаа***

Ясанд хэмжилт хийж шинж тэмдэг, онцлогоор дүгнэлт гаргах

## ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА

Сургалт нийт 88 долоо хоног үргэлжлэх ба заавал судлах, сонгон судлах, мэргэшүүлэх тойролтуудыг хийж гүйцэтгэсэн байна.

1. Заавал судлах тойролтоор 1 дүгээр дамжаанд 12 долоо хоног сургалтыг сургалт хариуцсан байгууллагын ментор багш, сургагч багш, мэргэжилтнүүд хариуцан зохион байгуулж үр дүнг сурлагын дэвтэрт тэмдэглэнэ.
2. Сонгон суралцах тойролт нь 1 дүгээр дамжаанд 2 долоо хоног, 2 дугаар дамжаанд 2 долоо хоног гэж тусгагдсан бөгөөд суралцагч батлагдсан хичээлүүдээс сонгон суралцаж үр дүнг тооцуулсан байна.
3. Мэргэшүүлэх тойролт нь 1 дүгээр дамжаанд 32 долоо хоног, 2 дугаар дамжаанд 40 долоо хоног байх ба үр дүнг тооцуулсан байна.

№	Тойролтын нэр	Долоо хоног	Сургалт эрхлэх байгууллага
<b>Заавал судлах /12 долоо хоног/</b>			
1.	Хүний анатоми ба хистологи <i>/Human anatomy and histology/</i>	4	Монгол Японы эмнэлэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
2.	Ерөнхий эмгэг судлалын үндэс <i>/Pathologic basis of Disease/</i>	8	Монгол Японы эмнэлэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
<b>Сонгон судлах хичээлийн тойролт /4 долоо хоног/</b>			
1.	Харилцааны ур чадвар <i>/Communication skills/</i>	2	Монгол Японы эмнэлэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
2.	Хууль эрх зүй <i>/Legal Law/</i>	2	Монгол Японы эмнэлэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
3.	Судалгааны арга зүй <i>/Research methodology/</i>	2	Монгол Японы эмнэлэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
4.	Илтгэх ур чадварын сургалт <i>/Presentation skills/</i>	2	Монгол Японы эмнэлэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
<b>Мэргэшүүлэх тойролт /72 долоо хоног/</b>			
1	Шүүх анагаах ухаанд тиохиолддог өвчин эмгэг, осол гэмтлийн ялган оношлогоо <i>(Forensic medicine I)</i>	10	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Монгол Японы эмнэлэг



2	Анатомийн эмгэг судлал, өвчний эмгэг судлалын үндэс, эмгэг судлалын задлан шинжилгээ, шүүх эд эсийн эмгэг судлал ( <i>Anatomical Pathology &amp; Forensic Histopathology</i> )	10	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль Монгол Японы эмнэлэг
3	Ураг нярайн эмгэг судла, эх барих эмэгтэйчүүдийн эмгэг судлал ( <i>Prenatal &amp; Pediatric pathology, Obs &amp; Gynecological Pathology</i> )	8	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Монгол Японы эмнэлэг, Эмгэг судлалын үндэсний төв
4	Шүүх гэмтэл судлал: Эрүүл мэндийн хохиролын зэрэг тогтоох, бэлгийн гэмт хэргийн болон нас тогтоох шүүх эмнэлгийн шинжилгээ ( <i>Forensic traumatology</i> )	10	Шүүх Эмнэлгийн Шинжилгээний Газар, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Монгол Японы эмнэлэг, Сүлжээ Сургалт эрхлэх байгууллага
